



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 75

Мөрөн

“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, 77 дугаар хуулийн 77.4, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 79 дүгээр зүйлийн 79.1, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийг төлөөлж оролцох гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Б.Болд-аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Х.Энхтуяа-аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Л.Гантулга – Аймгийн Татварын хэлтсийн дарга

Б.Базардамбуу - Аймгийн Статистикийн хэлтсийн дарга

Ц.Ганчимэг- Мөрөн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн

Д.Мөнхсаятан – Мөрөн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн

2. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд дараах хүмүүсийг томилсугай.

Э.Батболд- Аймгийн Улаан загалмай хорооны дарга

Б.Баасанхүү- “Сүүн тахилт” ТББ-ын тэргүүн

Н.Баттөр – Аймгийн ИТХ-ын төлөөлөгч

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2017 оны 05 дугаар сард багтаан хуралдуулж, удирдамжийг батлуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Гончиг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР